



Монгол Улсын Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төсөл

Агуулга

1. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах туршилтын төсөл
2. 3R тухай анхны семинар
3. Мэдээ мэдээлэл
4. Монгол хэл дээрх шинэ вэб хуудас

Манай төсөл хэрэгжиж эхлээд 8 сар болж байна. Энэхүү мэдээллийн тоймын 3 дахь дугаарт төслийн үйл ажиллагааны чухал бүрэлдэхүүн хэсэг болох “хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах туршилтын төсөл”-г танилцуулах болно.

1. Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах туршилтын төсөл

Төсөл хэрэгжүүлэх үндэслэл

2007 онд боловсруулсан Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн Мастер төлөвлөгөөний үндсэн зорилго нь “зорилтот 2020 он гэхэд Улаанбаатар хотод байгаль орчинд халгүй хатуу хог хаягдлын менежментийг тогтолцоо бий болгох”-д орших бөгөөд тэрхүү тогтолцооны хүрээнд хог хаягдлын 3R (багасга, дахин ашигла, дахин боловсруул) концепцийг нэвтрүүлж хэвшүүлэх үйл ажиллагааг дэмжиж түүнийг дараах шат дараалалтай хэрэгжүүлэх болно. Үүнд:

- 1) Айл өрх, ААН-ийн түвшинд хог хаягдлын үүсэх хэмжээг багасгахыг дэмжих.
- 2) Хог хаягдал үүсэх хэмжээг багасгах талаар чармайлт гаргасны дараа нэгэнт үүссэн хог хаягдлыг аль болох олон дахин ашиглах эсвэл дахин боловсруулалтанд оруулах.
- 3) Анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлын хэмжээг багасгах, дахин ашиглах эсвэл дахин боловсруулалтанд оруулах хүчин чармайлт гаргасны дараагаар үлдэгдэл хог хаягдлыг зөв зохистой байдлаар цуглуулж эцсийн шатанд төвлөрсөн хогийн цэг дээр байгаль орчинд халгүйгээр дарж булаах.
- 4) Төр, хувийн хэвшил ба иргэд тус тусын гүйцэтгэх үүрэг хариуцлагыг ухамсарлаж нээлттэй, шударга зарчмын дагуу ажилласнаар дээр дурьдсан хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоог бий болгох зэрэг болно.

2007 оноос хойш УБ хотод хогны машины парк шинэчлэлт хийх, эрүүл ахуйн шаардлага хангах ландфилын үйл ажиллагаатай шинэ төвлөрсөн

хогийн цэгийг барьж байгуулах зэрэг дэд бүтцийн чанартай асуудлуудыг шийдвэрлэхийн сацуу ХХҮС байгуулах, ХХМ-ийн бүтцийг бэхжүүлэх зэргээр менежментийн тогтолцоог сайжруулсан боловч 3R гэсэн үзэл санааг хог хаягдлын менежментэд нэвтрүүлж хэвшээгүй байгаа тул энэхүү туршилтын төсөл нь нийслэл хотын онцлог, нийгмийн хөгжлийн өнөөгийн түвшин, эрс тэс уур амьсгалтай цаг агаарын нөхцөл байдалд тохирох 3R асуудлыг хамт шийдсэн хатуу хог хаягдлын менежментийн тогтолцоог нэвтрүүлэхэд нийслэлийн төр, захиргааны байгууллагуудад дэмжлэг болох учиртай юм.

Туршилтын төсөл дараах гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд:


- ТТ1: Хог хаягдлыг ангилан хадгалж хаяхад иргэдийн оролцоог нэмэгдүүлж тэдгээрт хэвшүүлэх
- ТТ2: Хог хаягдлыг ангилан цуглуулах тогтолцоо хэрэгжих эсэхийг судлах
- ТТ3: Төвлөрсөн хогийн цэг дээр хог хаягдлыг ялгах тогтолцоо хэрэгжих эсэхийг судлах

Ерөнхий төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэхэд баримтлах бодлого:

- 1) Эхний шатанд анхан шатны эх үүсвэр дээр хог хаях хэмжээг багасгах буюу иргэд хогоо ангилан ялгадаг үйл ажиллагааг дэмжих.
- 2) Хог хаягдлыг дахин ашиглах боломжтой ба бусад гэсэн хоёр төрлөөр ангилан ялгуулах.
- 3) Хуванцар сав, шилэн сав, лонх, лааз, гялгар уут, цаас зэргийг дахин ашиглах боломжтой хог хаягдал гэж үзэх.
- 4) Ангилж ялгасан хог хаягдлыг тус тусад нь цуглуулдаг тогтолцоог нэвтрүүлэх боловч НЭХЦ рүү тээвэрлэх хогны хэмжээг багасгах зорилгоор иргэд, орцны жижүүр, ачигч нарын хог хаягдал ялгаж хоёрдогч түүхий эд авах цэгт борлуулах үйл ажиллагааг дэмжих
- 5) “Нарангийн Энгэрийн Рисайкл Цогцолбор” гэх хог хаягдал ялгах цехийг төвлөрсөн хогийн цэгт байгуулж хуванцар сав, шилэн лонх, лааз зэрэг дахин ашиглах боломжтой болон гялгар уут, цаас зэрэг RPF түлшний

түүхий эдийг тэрхүү цехэд ангилан ялгах. Дээр дурьдсан бодлогын хүрээнд хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах тогтолцоо хэрхэн хэрэгжих урсгалыг дараах схем зургаар үзүүлэв.



3 ТТ-ийн хэрэгжилтийн явц

ТТ1: Хог хаягдлыг ангилан хадгалж хаяхад иргэдийн оролцоог нэмэгдүүлж тэдгээрт хэвшүүлэх

Энэхүү туршилтын төслийн зорилго нь хог хаягдлыг ангилан хадгалж хаяхад нийслэл хотын иргэд ямар хэмжээнд оролцож хамтран ажиллах боломжтой эсэхийг судлахын зэрэгцээ орон сууцны хорооллын оршин суугч нартай уулзалт ярилцлага хийж иргэдийн мэдлэг ухамсарыг хэрхэн дээшлүүлэх талаар төсөл хэрэгжүүлэгч Монголын талын байгууллагуудын чадавхийг нэмэгдүүлэхэд оршино.

Төсөл хэрэгжүүлэх хороодыг сонгохдоо дүүрэг, хороодын удирдлагын ХХМ-ийн тогтолцоог сайжруулж туршилтын төслийн үйл ажиллагааг дэмжиж ажиллах хүсэл эрмэлзэл, ангилан цуглуулах тогтолцоог нэвтрүүлэхтэй холбогдон гарах нэмэлт зардлыг шийдвэрлэх боломж байгаа зэргийг судалж улмаар СБД-ийн 5 ба 7, БЗД-ийн 1 ба 7 гэсэн дөрвөн хороодыг сонгов.

Одоогийн байдлаар сонгож авсан хороодын СӨХ-ийн төлөөлөгч нартай долоо хоног тутам уулзалт ярилцлага зохион байгуулж байна. Тэдгээр уулзалтаар юуны түүрүүнд, 1)иргэдийн хогоо хаядаг өнөөгийн хэв маягийг еерчилж сайжруулах, 2)хог тээвэрлэгч байгууллагуудын хогоо ачиж цуглуулдаг өнөөгийн байдлыг сайжруулах, 3)анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилан



ялгах талаар иргэдийн оролцоог нэмэгдүүлж тэдгээрт хэвшүүлсний дараагаар хог хаягдлыг ангилан цуглуулдаг тогтолцоог нэвтрүүлэх нь

зүйтэй гэсэн шийдвэр гарган ажиллаж байна.

ТТ2: Хог хаягдлыг ангилан цуглуулах тогтолцоо хэрэгжих эсэхийг судлах

Энэ туршилтын төсөл нь орон сууцны хорооллын хог хаягдлыг ангилан цуглуулдаг ба холимог байдлаар цуглуулдаг хороодыг сонгож тогтолцоо тус бүрийн зардал (ангилан ялгах болон цуглуулах зардал) болон үр өгөөж (хаягдал түүхий эдийн хэмжээ ба түүний борлуулалтаас орох орлого)-ийг хооронд нь харьцуулан судалж улмаар иргэдийг хог хаягдал ангилан ялгах ба цуглуулах тогтолцоог Улаанбаатар хотод нэвтрүүлэх шаардлага байгаа эсэх тухай мэдээлэл, ойлголттой болгох зорилготой.

Энэ төслийг дээр дурдсан эхний туршилтын төсөл амжилттай хэрэгжиж иргэд тодорхой хэмжээгээр хогоо ангилан ялгаж хэвшсэний үндсэн дээр хэрэгжүүлэх болно.

ТТ3: Төвлөрсөн хогийн цэг дээр хог хаягдлыг ялгах тогтолцоо хэрэгжих эсэхийг судлах

Энэ төслийн зорилго нь хог түүгчид хоёрдогч түүхий эдийг хог хаягдал замбараагүй тархах байдлаас сэргийлсэн торон хашаатай бетон тавцан дээр энгийн гар аргаар ба конвейер ашиглан хагас механикжуулсан байдлаар ангилан ялгах тогтолцооны зардал, үр өгөжийг харьцуулан судлахад оршино.

НЭХЦ-т 250 орчим хог түүгч нар хаягдал түүхий эдийг өөрсдийн амьжиргааны эх үүсвэр болгон цуглуулж байна. Ялгах цех барьж ашиглалтанд оруулснаар тэдгээр хог түүгч нар ялгах цех дотор аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангасан орчинд ажиллах боломжтой болохын сацуу НЭХЦ дээр ландфилын үйл ажиллагааг илүү үр өгөөжтэй явуулах боломжтой болох юм. Ялгах цех ашиглалтанд ормогц хаягдал түүхий эд ангилан ялгах үйл ажиллагааг эхлүүлэхийн тулд хог түүгч нарыг зохион байгуулалтанд оруулж долоо хоног тутмын уулзалтыг хийж байна.

Хог хаягдал ангилан ялгах, дахин боловсруулах ТТ-ийг хэрэгжүүлэх хуваарь

Тайлбар	2009												2010												2011											
	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
Туршилтын төслийг хэрэгжүүлэх төлөвлөгөө	← Хэрэгжилт үе шат →																																			
Хог хаягдлыг хадгалах ба хаях	[Progress bars]																																			
1.Хогоо зөв зохиотой хаягдаж байдалыг сайжруулах	[Progress bars]																																			
2.Эх үүсвэр дээр хогийг ангилан ялгах(Борлуулах боломжтой хаягдал түүхий эд ба буцад)	[Progress bars]																																			
3.Эх үүсвэр дээр хогийг ангилан ялгах (дахин боловсруулах боломжтой хаягдал түүхий эд ба буцад)	[Progress bars]																																			
Хог хаягдлыг ангилан цуглуулах	[Progress bars]																																			
1.Хогоо энэ зохиотой өндөр байдлыг сайжруулах(тодорхой цэгээс унаварийн дагуу)	[Progress bars]																																			
2.Хог ачиж үйл ажиллагааны үр ашгийг сайжруулах	[Progress bars]																																			
3.Хаягдал түүхий эдийг ангилан цуглуулах	[Progress bars]																																			
НЭХЦ дээр хог хаягдлыг ангилан ялгах	[Progress bars]																																			
1.Ялгах цэгийг барих	[Progress bars]																																			
2.Холимог хог хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагаа	[Progress bars]																																			
3.Ангилсан хог хаягдлыг ангилан ялгах үйл ажиллагаа	[Progress bars]																																			
Хяналт	[Progress bars]																																			
Дүгнэлт ба зөвлөмж	[Progress bars]																																			

Борлуулах боломжтой хаягдал түүхий эд: хуванцар сав, шилэн лонх, гявц, цэвэрлэн цаас г.м.
Дахин боловсруулах боломжтой хаягдал түүхий эд: Борлуулах боломжтой түүхий эд + RFF түүхий материал(мушчарын цаас, хуванцар)

2. 3R тухай анхны семинар

Энэ оны 4 дүгээр сарын 14-нд дараах зорилго бүхий 3R тухай анхны семинарыг Улаанбаатар зочид буудалд зохион байгуулав. Үүнд:

- 1) Туршилтын төслийн агуулга, түүнийг хэрхэн хэрэгжүүлэх талаар холбогдох талуудын хооронд харилцан ойлголцол бий болгож тэдгээрийн дэмжлэгийг авах,
- 2) Төвлөрсөн хогийн цэг дээр дарж булах хог хаягдлын хэмжээг багасгах, хог хаягдлыг дахин боловсруулах чиглэлээр 3R үйл ажиллагааг дэмжихэд холбогдох талуудын хуримтлуулсан мэдлэг, туршлагыг солилцох,
- 3) 3R үйл ажиллагааг сурталчилж нийтэд түгээх чиглэлээр холбогдох талуудын санал бодлыг солилцох боломжийг олгох.

Холбогдох яам, ЗАА-ны ОБХХМХ, ХТГ, ХХҮС, дүүргүүдийн ҮҮХ, төсөл хэрэгжих хороодын СӨХ, ТББ, хэвлэл мэдээлэл зэрэг байгууллагуудын 90 орчим төлөөлөгчид семинарт оролцов.

Монгол ба Японы талын албаны төлөөлөгчид семинарыг нээж үг хэлсний дараа хог хаягдал ангилан ялгах, дахин

боловсруулах туршилтын төслийн тухай дэлгэрэнгүй танилцуулгыг ЗАА-ны ОБХХМХ хийж улмаар оршин суугчдын

хэмжээнд хог хаягдал ангилан ялгах үйл ажиллагааг хэрэгжиж байгаа СБД-ийн 7-р хорооны туршлага, тулгамдаж буй асуудлуудын тухай тус хорооны Засаг дарга танилцуулав.

Семинарын асуулт, хариултын цагт “Тогтвортой хөгжлийн жендерийн төв” ТББ-ын төлөөлөгч “RPF¹ түлшийг хаягдал цаас, хуванцараар хийж шатаах

тохиолдолд ялгарах хорт хийний эсрэг ямар арга хэмжээ авах вэ” гэж асуув.

ЖАЙКА-ийн зөвлөх багийн

зүгээс хөгжлийн судалгааны үед Налайх дүүргийн ДЦС дээр хийсэн туршилтын төслийн талаар мэдээлэл хийв. Хөгжлийн судалгааны үед хэрэгжүүлсэн тэрхүү туршилтын төслийн үер RPF түлшийг бага хэмжээгээр нүүрстэй



хольж шатаасан бөгөөд шаталтаас гарах ялгарах хийний хэмжилт хийж зөвшөөрөгдөх хэмжээнд байгааг тогтоосон. Түүнчлэн, RPF нь түлшний шаталтыг сайжруулж байгааг харуулсан боловч RPF-ийг дангаар нь ДЦС-ын зууханд шатааж ашиглах зөвлөмжийг төслийн зүгээс гаргаагүй болно.

Иргэд, оршин суугчдын хэмжээнд хог хаягдлыг ангилан ялгах, дахин ашиглах, боловсруулалтанд оруулах талаар Нийгмийн эрүүл мэндийн

хүрээлэнгийн төлөөлөгч хог хаягдлыг анхан шатны эх үүсвэр буюу хог хаягдлыг цуглуулахаас нь өмнө хийх ач холбогдлыг дурдаж төслийн хүрээнд тодорхой үр дүнд хүрэхийн тулд айл өрхийн гэрийн эзэгтэй, хүүхэд болон олон нийтийн сургалт сурталчилгааны ажлыг сайтар хийхийг зөвлөв.

Семинарын хоёр дахь хэсэгт ЗАА-ны ОБХХМХ Улаанбаатар хотын иргэд, байгууллагуудын хогоо хаядаг өнөөгийн хэв маяг болон түүнтэй холбоотой тулгамдаж буй асуудлуудын талаар танилцуулж дараа нь семинарт оролцогч нар 4 хэсэгт хувагдаж хог хаядаг болон ачдаг өнөөгийн хэв маягийг хэрхэн өөрчилж сайжруулах боломж, иргэдийн хог хаягдал ангилан ялгах, дахин ашиглах үйл ажиллагааг хэрхэн дэмжих талаар ярилцлага өрнүүлэв.

Тэрхүү ярилцлагад СӨХ-ийн төлөөлөгч нар идэвхтэй оролцон санал бодлоо солилцож улмаар хэсгийн төлөөлөгч тус бүр ярилцлагын дүнг тус тус танилцуулав.

Төсөл хэрэгжүүлэх хорооны байр нь бункертэй эсэхээс хамаарч иргэдийн хогоо хаядаг хэв маяг өөр өөр байдгаас гадна хог тээвэрлэгч компани болон ашиглаж байгаа хогны машины төрлөөс хамаарч хог хаягдал цуглуулдаг арга ч өөр өөр байдаг байна. Түүнчлэн, зарим хороод нь анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилан ялгах ажлыг тодорхой хэмжээнд эхлүүлсэн

Тэрхүү ярилцлагад СӨХ-ийн төлөөлөгч нар идэвхтэй оролцон санал бодлоо солилцож улмаар хэсгийн төлөөлөгч тус бүр ярилцлагын дүнг тус тус танилцуулав.

Төсөл хэрэгжүүлэх хорооны байр нь бункертэй эсэхээс хамаарч иргэдийн хогоо хаядаг хэв маяг өөр өөр байдгаас гадна хог тээвэрлэгч компани болон ашиглаж байгаа хогны машины төрлөөс хамаарч хог хаягдал цуглуулдаг арга ч өөр өөр байдаг байна. Түүнчлэн, зарим хороод нь анхан шатны эх үүсвэр дээр хог хаягдлыг ангилан ялгах ажлыг тодорхой хэмжээнд эхлүүлсэн



¹ RPF – хаягдал цаас, хуванцарыг нягтруулж тодорхой хэлбэр, хэвэнд оруулаад ДЦС-д түлш маягаар ашигладаг

байхад зарим хороод нь иргэд, оршин суугчид гэхээхээ илүү ААН-дийн хогоо замбараагүй хаядаг хүндхэн асуудлуудтай тулгарч байх жишээтэй байна. Иймд, хороо тус бүрийн онцлог байдлаас хамаарч гарах арга зам, шийдлийн тухай ярилцаж тухайн хорооны бодит нөхцөл байдлыг үндэслэн туршилтын төслийн агуулга, арга хэмжээнүүдийг тодорхойлохоор болов.

Семинарын эцэст оролцогч нарын зүгээс өөрсдийн санал зөвлөмжүүдийг өгч байв. БЗД-ийн 1 дүгээр хорооны СӨХ-ийн төлөөлөгч хэвлэл мэдээллийн хэрэгсэл, ялангуяа Монголд

телевизийн суваг ашиглах нь хамгийн хүчтэй сурталчилгаа болох тул туршилтын төслийн

хэрэгжилтийн явц, амжилт, үр дүнг

Нийслэлийн UBS телевизийн I ба II сувгийг ашиглаж сурталчилгаа хийхийн зэрэгцээ хогны асуудалтай холбоотой хууль журам зөрчсөн этгээдүүдийг ч телевизээр гаргаж байх шаардлагатайг зөвлөж байв.

БЗД-ийн 7-р хорооны СӨХ-ийн төлөөлөгч төслийг үр өгөөжтэй хэрэгжүүлэхийн тулд өрсөлдөөн бий болгох чухлыг дурдаад “туршилтын төслийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд СӨХ болон айлуудын хооронд уралдаан зарлаж иргэдийн хогоо хаях хэв маягийг сайжруулах талаар идэвхтэй ажилласан СӨХ, айлуудыг Нийслэлийн зүгээс урамшуулал, дэмжлэг үзүүлэх шаардлагатай” гэв.

ЖАЙКА-ийн зөвлөх багийн зүгээс хог хаягдал цуглуулах давтамжийн талаар “БЗД-ийн 7-р

хорооны зарим оршин суугчид нь хогоо гэртээ 2 хоног хадгалж хэвшсэн туршлага дээр үндэслэн Улаанбаатар хотод хог хаягдал

цуглуулах давтамжийг цөөрүүлэх боломж нь байгаа тул төслийн зүгээс хог хаягдлаа зөвхөн 2-3 хоног хадгалах санал тавьсан. Японд хүнсний хог хаягдлыг нэг долоо хоногт 2 удаа хаяж болдог бол бусад хог хаягдлыг 2 долоо хоногт 1 удаа л цуглуулдаг. Ийм байдлаар хуваарийн дагуу хог хаядаг байдлыг хэвшүүлэх нь хог хаягдлын тухай иргэдийн мэдлэг ухамсар дээшилдэг” гэв.

Иргэдийн ангилан ялгасан хог хаягдлыг хийх гялгар уутаар



хангаж өгөх саналыг семинарт оролцогч нар тавьсан боловч ЖАЙКА-ийн зөвлөх багийн зүгээс “Хог хаягдлын хэмжээг бууруулах зорилготой туршилтын төслийн хүрээнд гялгар уутыг иргэдэд тарааж өгөх нь хаягдал гялгар уутны хэмжээг нэмэгдүүлэхийн

зэрэгцээ гялгар уутаар хангах хөрөнгийг олж авах нь нэлээд хүндрэлтэй байдаг тул тогтвортой үйл ажиллагаа болохгүй. Заавал

тарааж өгөх хэрэгцээ байна гэж үзвэл найдвартай, тогтмол хангах хөрөнгийн эх үүсвэрийг урьдчилан баталгаажуулах шаардлагатай. Ангилан хаях, цуглуулах тогтолцоог нэвтрүүлснээр хог хаягдлын хэмжээ буурна. Ингэснээр цуглуулах давтамж багасч тээвэрлэгч байгууллагуудад хуримтлал үүсэх ба үүнийг гялгар уут нийлүүлэх санхүүгийн эх үүсвэр болгон ашиглах боломжтой” гэв.

Семинарын үер өрнүүлсэн ярилцлагын дүнд семинарт оролцогчид хог хаягдлын менежментийн холбогдолтой асуудлуудаар санал бодлоо солилцож туршилтын төслийн тухай нэгдсэн ойлголтыг бий болгов. Семинарын үер хуримтлуулсан туршлага, ярилцсан асуудлууд ба гарсан саналуудыг туршилтын төслийг хэрэгжүүлэхэд аль болох үр ашигтай хэлбэрээр тусгахаар төлөвлөж байна.



3. Мэдээ мэдээлэл

- Туршилтын төсөл хэрэгжүүлэх хороодын СӨХ-ийн уулзалт: хэрэгжих шатанд.
- БЗД-ийн 1-р хороонд хог хаягдлыг ангилан цуглуулах туршилт: VI/12-ноос.
- НЭХЦ-ийн хог түүгч нарын уулзалт: хэрэгжих шатанд.
- Гэр хорооллын хог хаягдлыг цуглуулах ажлын цагийн зураг авалт: 6-р сарын дунд.

4. Монгол хэл дээрх шинэ вэб хуудас

Төслийн монгол хэл дээрх вэб хуудас бэлэн болов. Вэб хуудасны хаягийг доор үзүүлэв. Манай төслийн холбогдолтой тайлан мэдээ болон семинар, хурлын тухай мэдээллийг цаг тухайд нь уншигч Та бүгдэд хүргэх зорилгоор интернет дээрх вэб хуудсыг байнга шинэчилж байх болно. Манай вэб хуудастай уншигч Танд танилцах боломж олддоно гэдэгт бид найдаж байна.

Улаанбаатар хотын хатуу хог хаягдлын менежментийн чадавхийг бэхжүүлэх техникийн хамтын ажиллагааны төслийн ЖАЙКА-ийн зөвлөх баг

[Ажлын байрны хаяг]

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Г.Бумцэнд-68, Хот тохижилтын газрын байр

Утас: 327128, Факс: 323128

Вэб хуудас: <http://www.kkcub.mn/>